



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 11/181

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаал “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4, сумын Засаг даргын зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 12-ний өдрийн 09 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Албан байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу нийтийн эзэмшлийн орон сууцнуудын подвалын шугам сүлжээний гэмтлийг засварлахад 3478400 (гурван сая дөрвөн зуун далан найман мянга дөрвөн зуу) төгрөг, нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн засвар үйлчилгээнд 3710000 (гурван сая долоон зуун арван мянга) төгрөг, Соёлын төвийн дээврийн засварын ажилд 195000 (нэг зуун ерэн таван мянга) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх ажлуудад зарцуулагдах 7383400 (долоон сая гурван зуун наян гурван мянга дөрвөн зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг нягтлан бодогч (Б.Энхмаа)-д зөвшөөрсүгэй.

3. Холбогдох ажлыг зохион байгуулж, санхүүгийн баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллахыг нягтлан бодогч /Б.Энхмаа/-д, дээрх ажлуудыг чанартай гүйцэтгэж, хэрэгжүүлэхийг хүсэлт ирүүлсэн (байгууллагын дарга нарт), захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

42121 644